

**СЭНДБОКСЫН ОРЧНЫ
ТОЙМ**

2023 оны IV улирал

АГУУЛГА

НЭГ.	СЭНДБОКСОД ТУРШИГДАЖ БУЙ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ	3
1.1	Инсуртекийн үйлчилгээ	4
1.2	Репо хэлцэл зуучлалын үйлчилгээ	5
1.3	P2P зээлийн үйлчилгээ	7
1.4	Хамтын санхүүжилтийн үйлчилгээ	9
ХОЁР.	БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ	10

ХОЛБОО БАРИХ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР,
СЭНДБОКСЫН АЛБА

УТАС: 51-261106

И-МЭЙЛ: SANDBOX@FRC.MN

ХАЯГ: ЗАСГИЙН ГАЗРЫН IV БАЙР, БАГА ТОЙРУУ 3,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, УЛААНБААТАР ХОТ, 15160

СЭНДБОКСОД ТУРШИГДАЖ БУЙ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

Сэндбоксоод ирүүлсэн хүсэлт, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөр

Сэндбоксын орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ турших 19 хүсэлт ирсэн бөгөөд эдгээрээс 8 бүтээгдэхүүн, үйлчилгээг Сэндбоксын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж 7 бүтээгдэхүүн сэндбоксын орчинд орсон.



Сэндбоксын орчинд орсон бүтээгдэхүүн, үйлчилгээ

2023 оны эцсийн байдлаар нийт 7 бүтээгдэхүүн, үйлчилгээ сэндбоксын орчинд орсноос 1 үйлчилгээ 1 жилийн хугацаанд туршигдан сэндбоксоос гарч, 1 үйлчилгээ туршилтын хугацаагаа ахин 1 жилээр сунгаж, 5 үйлчилгээ сэндбоксын орчинд шинээр орон туршигдаж байна.



Монпэй дижитал бонд нь 2021.11.01–ний өдрөөс эхлэн 1 жилийн хугацаанд сэндбоксын орчинд туршигдаж 2022.12.30–ны өдөр сэндбокс зохицуулалтын орчноос гарсан.



P2P зээлийн үйлчилгээ. 2022.12.30–ны өдөр Сэндбоксын орчинд орсон.



ББСБ–уудын репо хэлцлийн зуучлалын платформын үйлчилгээ. 2022.12.30–ны өдөр сэндбокс туршилтын хугацааг ахин 1 жилээр сунгасан.



Лайка платфрмоор хүргэж буй инсуртек үйлчилгээ. 2022.12.30–ны өдөр Сэндбокс орчинд орсон.



Платформд суурилсан зээл, урамшуулал, хандивын хамтын санхүүжилтийн үйлчилгээ. 2022.12.30–ны өдөр Сэндбокс орчинд орсон.



Урамшуулал, хандив, хөрөнгө оруулалтад суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээ. 2023.11.07–ны өдөр Сэндбокс орчинд орсон.



Биржийн бус зах зээлийн блокчэйн арилжааны систем 2023.11.07–ны өдөр Сэндбокс орчинд орсон.

Репо хэлцэл зуучлалын үйлчилгээ



Репо хэлцэл зуучлалын үйлчилгээ нь 2021.12.17-ны өдөр сэндрокс орчинд орсон бөгөөд 2022 онд Сэндрокс зохицуулалтын орчинд үйл ажиллагаа явуулах хугацааг сунгах хүсэлтийг гаргаж тус хүсэлтийн дагуу 2022.12.30-ны өдрийн 05 дугаар зөвлөмж, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 557 дугаар тушаалаар сэндроксын хугацааг сунган мөнгөний захад хадгаламжийн сертификат, арилжааны бичиг, факторинг (хямдруулсан нэхэмжлэл), итгэлцлийн үйлчилгээг нэвтрүүлэх төлбөр тооцоо, бүртгэл, хадгалалтын нэгдсэн платформыг хөгжүүлж 2 дахь жилдээ туршиж байна.



Хадгаламжийн сертификат

2023 оны 9 дүгээр сарын 6-ны өдрөөс эхлэн Хадгаламжийн сертификат арилжаалагдаж эхэлснээс хойш 2023 оны эцсийн байдлаар нийт 52.5 сая төгрөгийн Хадгаламжийн сертификат арилжаалагдсан байна.

Арилжааны дүн



52.5 сая

Итгэлцэл

2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс мөн Итгэлцлийн арилжааг шинээр эхлүүлж, Микро Кредит ББСБ ХХК-ийн 6 болон 12 сарын хугацаатай нийт 200.0 сая төгрөгийн итгэлцлийг 17.00%, 20.00% хувийн үр шимээр арилжааллаа.

Арилжааны дүн



200 сая



Худалдагч



972

удаагийн хэлцэл



Платформ

Худалдан авагч

179.7 тэрбум
төгрөгийн арилжаа

Репо хэлцэл зуучлалын үйлчилгээ нь 2021 оны 12 дугаар сараас эхлэн мөнгөний захын зуучлалын үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд репо хэлцэл зуучлалын платформ дээр 35 зээлдүүлэгч, 31 зээлдэгч оролцон нийт 179.7 тэрбум төгрөгийн 972 удаагийн арилжаа хийсэн байна. Мөн 2023 оны IV улиралд мөнгөний зах нь нийт 177 удаагийн 109.8 тэрбум төгрөгийн илүүдэл нийлүүлэлт, 1 удаагийн 100 сая төгрөгийн илүүдэл эрэлт байсан. Репо хэлцлийн платформоор хийгдэж буй зээлийн дундаж хугацаа 37 хоног, харин репо зээлийн дундаж хүү 18.6 хувьтай байна.



Репо зээлийн дундаж хүү

18.6%

Репо зээлийн дундаж хугацаа 37 хоног



7 хоног

14 хоног

28 хоног


84 хоног

2023 оны IV улирлын байдлаар мөнгөний зах зээлийн ерөнхий төлөв байдлыг илэрхийлэх статистик үзүүлэлтүүдийг Хүснэгт 1–д тоймлон харууллаа.

Хугацаа	Зээлдүүлэгчийн тоо	Зээлдэгчийн тоо	Арилжааны тоо	Арилжааны дүн	Дундаж хүү	Зээлийн дундаж хугацаа
I улирал	18	14	149	30,120,000,000	17.16	31
II улирал	17	19	117	24,250,000,000	17.11	31
III улирал	16	20	140	30,840,000,000	18.56	35
IV улирал	13	18	127	30,470,000,000	18.64	37
Нийт	–	–	533	115,680,000,000	17.8675	34


Зураг 1–д мөнгөний захын 2023 оны хүүгийн түвшин болон арилжааны дүнг харуулав. 2023 оны IV улиралд мөнгөний зах дээр хийгдсэн нийт репо хэлцлийн дүн өмнөх улирлаас 1.2 хувиар буурч, 30.4 тэрбум боллоо. Мөнгөний захын арилжааг бүтээгдэхүүнээр нь ангилан харвал 2 долоо хоногийн хугацаатай репо зээлийн хэлцэл маш бага хийгдсэн бол 4 долоо хоногийн хугацаатай репо зээл нь мөнгөний захын хамгийн эрэлттэй бүтээгдэхүүн байна. Тухайлбал 2023 оны IV улирлын байдлаар хийгдсэн нийт репо хэлцлийн 71 хувийг 4 долоо хоногийн хугацаатай, 21 хувийг 12 долоо хоногийн хугацаатай, 4.9 хувийг 1 долоо хоногийн хугацаатай, 3.1 хувийг 2 долоо хоногийн хугацаатай репо хэлцлүүд тус тус эзэлж байна.

Зураг 1. Мөнгөний захын хүүгийн түвшин ба арилжааны дүн, репо зээлийн хугацаагаар



Түүнчлэн мөнгөний захад репо зээл 2023 оны IV улирлын байдлаар биелсэн хэлцлийн тоо болон арилжааны дүнг өмнөх улиралтай харьцуулахад биелсэн хэлцлийн тоо 13–аар, нийт арилжааны дүн 1.2 хувиар буурсан бол жилийн жигнэсэн дундаж хүү нь 0.1 пунктээр өссөн байна.

Хамтын санхүүжилтын үйлчилгээ



Хамтын санхүүжилтийн үйлчилгээ нь 2022.12.30–ны өдрөөс эхлэн сэндбоксын орчинд орж хамтын санхүүжилтийн үйлчилгээ буюу краудфандинг үйлчилгээгээ туршиж байна. Одоогоор тус байгууллага нь урамшуулалд суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээг сэндбоксын орчинд туршиж байгаа бол зээл, хандивт суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээг үе шаттайгаар нэвтрүүлэн ажиллаж байна.

Төслийн дундаж хугацаа 15 хоног



Урамшуулалд суурилсан хамтын санхүүжилтийн дүн

44.7 сая

331

Хөрөнгө оруулагч



8 төслийн санхүүжилт

Тус компани нь 2023 оны 2 дугаар сараас эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд 2023 оны IV улирлын байдлаар урамшуулалд суурилсан хамтын санхүүжилтийн 8 төсөлд 331 хөрөнгө оруулагчаас нийт 44.7 сая төгрөгийн санхүүжилт татан төвлөрүүлээд байна.


Платформоор санхүүжилт босгосон эдгээр 8 төслийн 7 төсөл нь 1 сараас бага хугацаатай төслүүд бөгөөд төслийн дундаж хугацаа 15 хоног байна.

Урамшуулалд суурилсан хамтын санхүүжилтийн төслүүдийн хувьд дунджаар нийт шаардлагатай санхүүжилтийг 56.1%–ын биелэлттэйгээр босгосон бөгөөд төслүүдийн санхүүжилтээ босгосон дундаж хугацаа 11 хоног байна.

2023 оны IV улирлын байдлаар тус платформ дээр хандивт суурилсан хамтын санхүүжилтийн 6 төсөл нийтлэгдсэн бөгөөд нийт 195 хүнээс 8.9 сая төгрөгийн хандивыг босгосон байна.

Мөн зээлд суурилсан Зээлийн 1 төсөл хэрэгжиж 2 хөрөнгө оруулагчаас 11 сая төгрөгийн санхүүжилт босгосон.

6 хандивын санхүүжилт



Платформоор дамжуулсан урамшуулалт санхүүжилтийн төслүүдэд хөрөнгө оруулсан хөрөнгө оруулагчдын 76.3 хувь нь 18–35 нас, 18.9 хувь нь 36–45 нас, 4.1 хувь нь 46–55 нас, 0.7 хувь нь 55–аас дээш насныхан байна.

Хөрөнгө оруулагчид насны бүлгээр

18–35 нас



76.3%

36–45 нас



18.9%

46–55 нас



4.1%

55–аас дээш





0.7%

P2P зээлийн үйлчилгээ



P2P зээлийн үйлчилгээ нь 2022.12.30-ны өдөр Сэндбоксын орчинд орсон бөгөөд хиймэл оюун ухаан, блокчэйн технологийг зээлийн үнэлгээ, бүртгэлдээ ашиглан хөрөнгө оруулагч, зээлдэгч хоёрыг шууд холбох үйлчилгээ юм.



98.8%
зээлдэгч



1.2%
хөрөнгө оруулагч

P2P зээлийн үйлчилгээ нь 2023 оны 2 дугаар сараас эхлэн зах зээлд нэвтэрч эхэлсэн бөгөөд 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар тус платформоор 5485 харилцагч P2P зээлийн үйлчилгээг хүртжээ. Эдгээр харилцагчдын 1.2 хувь нь хөрөнгө оруулагч, үлдсэн 98.8 хувь нь зээлдэгч байна.


Платформоор нийт 1.7 тэрбум төгрөгийн зээл олгогдсон бөгөөд үүнээс 759.3 сая төгрөгийн зээл нь эргэн төлөгдөж P2P нийт зээлийн үлдэгдэл 941.3 сая төгрөг байна. Мөн P2P зээлийн сарын жигнэсэн дундаж хүү 2.0 хувь байгаа бөгөөд олгосон зээлийн багцын 86.8 хувийг 3 сараас бага хугацаатай, 12.2 хувийг 4–6 сарын хугацаатай, 1.0 хувийг 7–9 сарын хугацаатай зээл бүрдүүлж байна. Харин тус платформоор дамжсан хөрөнгө оруулалтын багцын 42.1 хувийг 1 жилийн хугацаатай, 57.9 хувийг 1 жилээс бага хугацаатай хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлж байна.




3–9 сарын хугацаатай



Хэвийн
98.2%



Хугацаа хэтэрсэн
1.3%



Чанаргүй
0.5%

P2P платформоор зуучлагдан олгогдсон нийт зээлийн үлдэгдлийн 98.2 хувь нь хэвийн, 1.3 хувь нь хугацаа хэтэрсэн, 0.5 хувь нь чанаргүй гэсэн тус тус ангилалтай байна. Мөн P2P зээлийн сарын жигнэсэн дундаж хүү 2.0% –тай байна.

ЭМЭГТЭЙ



65.2%

ЭРЭГТЭЙ



34.8%

P2P зээлийн үйлчилгээний нийт харилцагчдын 65.2 хувь нь эмэгтэй, 34.8 хувь нь эрэгтэй харилцагчид байна. Харин нийт харилцагчдын 54.1 хувийг 18–35 насныхан, 32.4 хувийг 36–45 насныхан, 11.2 хувийг 46–55 насныхан, 2.3 хувийг 55–аас дээш насныхан тус тус бүрдүүлж байна. Харилцагчдыг боловсролын түвшнээр ангилбал 62.3 хувь нь дээд, 4.1 хувь нь тусгай дунд, 27.8 хувь нь бүрэн дунд, 4.4 хувь нь дунд, 1.4 хувь нь бага боловсролтой байна.

Насны бүлгээр

18–35 нас



54.1%

36–45 нас



32.4%

46–55 нас



11.2%

55–аас дээш



2.3%

Боловсролын түвшнээр



Дээд

Тусгай
дундБүрэн
дунд

Дунд

Бага

62.3%

4.1%

27.8%

4.4%

1.4%

СЭНДБОКСОД ТУРШИГДАЖ БУЙ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

Инсуртекийн үйлчилгээ



Инсуртекийн үйлчилгээ нь 2022.12.30–ны өдөр сэндбоксын орчинд орсон ба тус үйлчилгээ нь хэрэглэгч өөрийн хэрэгцээ шаардлага, эрсдэлд нийцсэн даатгалын бүтээгдэхүүнийг ямар нэгэн зуучлагчгүйгээр өөрөө сонгон хэрэглэх, мөн эрсдэлд суурилсан газрын зураглалыг хөгжүүлж, даатгалын эрсдэлийг үнэлэх давуу талтай.



1606
Бүртгэлтэй

315 даатгуулагч

5 хэлбэр

15 төрөл



Инсуртекийн үйлчилгээний платформд бүртгэлтэй 1606 харилцагч байна. Тус платформ нь смарт төхөөрөмж, жолоочийн хариуцлага, эрүүл мэнд, гэнэтийн ослын зэрэг 5 хэлбэр, 15 төрлийн даатгалын үйлчилгээг 315 даатгуулагчид хүргэсэн.

Эдгээр даатгалын бүтээгдэхүүнүүд нь нийт 1.12 тэрбум төгрөгийн үнэлгээтэй бөгөөд нийт хураамжийн орлогын 0.1 хувийг смарт төхөөрөмжийн даатгал, 12.5 хувийг жолоочийн хариуцлагын даатгал, 86.3 хувийг эрүүл мэндийн даатгал, 1.1 хувийг авто тээврийн даатгал тус тус бүрдүүлж байна.

Смарт төхөөрөмжийн
даатгал



0.1%

Жолоочийн хариуцлагын
даатгал



12.5%

Авто тээврийн
даатгал



1.1%

Эрүүл мэндийн
даатгал



86.3%



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ

Сэндбокс зохицуулалтын орчныг сайжруулах ажлын хүрээнд:

Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 190/71/А-72 дугаар хамтарсан тушаалаар “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ыг шинэчлэн баталсан.

Ухаалаг, тогтвортой, хүртээмжтэй санхүүгийн салбарыг хөгжүүлэх технологийн дэвшил, инновацыг ашиглах хүрээнд “Санхүүгийн инновац текспринт” уралдааныг “Unread Media” – тай хамтран зохион байгуулсан.




Сэндбокс зохицуулалтын орчин гарын авлагатай болсон.

Технологид суурилсан санхүүгийн зах зээлийн хөгжлийг хурдасгах “Финтек зохицуулалтын инновац хаб” байгуулах суурь судалгааг боловсруулан, Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй техник туслалцааны хүрээнд Монгол Улсын “Финтек зах зээлийн экосистемийг хөгжүүлэх” чиглэлд төслийг хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллаж байна.


Сэндбоксын орчны оролцогчдод хяналт тавих, хамтран ажиллах ажлын хүрээнд:

2023 оны жилийн эцсийн байдлаар Сэндбокс орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ турших хүсэлтэй нийт 19 компанитай 34 удаагийн уулзалтыг зохион байгуулсан.



Сэндбоксод туршигдаж буй 6 бүтээгдэхүүн тус бүрд тохирсон тайлан, мэдээний маягыг боловсруулан 7 хоног, сар, улирлын тайлан, мэдээг төвлөрүүлэн тоон мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна.

Оролцогчдоос ирсэн тайлан мэдээнд суурилан зайны хяналтыг тогтмол гүйцэтгэн, газар дээрх хяналт, үзлэгийг мөн гүйцэтгэн ажиллаж байна.



Финтекийн хөгжил болон зохицуулалтын орчны талаарх цахим болон танхимын сургалт, уулзалтуудад тогтмол оролцож байна.



Сэндбоксод туршигдаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний олон улс дахь хөгжил, зохицуулалтын орчны судалгааг тогтмол гүйцэтгэн ажиллаж байна.



